



ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР
9-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХООЛНЫ
ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН
БАРИМТ БИЧИГ

Тендер [Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнс]
шалгаруулалтын
нэр:

Тендер [ОРА9Ц/202401009]
шалгаруулалтын
дугаар:

САНАМЖ

Тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл болох тул тендер шалгаруулалт зохион байгуулах, түүнд оролцохын өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнийг даган батлагдсан журам, заавар, дүрэм, гэрээний нөхцөл, тендер шалгаруулалтын жишиг баримт бичигтэй сайтар танилцахыг зөвлөж байна.

Захиалагч нь тендер шалгаруулалт зохион байгуулахад худалдан авах ажиллагааны үндсэн зарчмууд болох өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, хариуцлагатай, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг баримтална.

Энэхүү харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын баримт бичиг нь тендер шалгаруулалтын зааварчилгаа, өгөгдлийн хүснэгт, техникийн тодорхойлолтын шаардлага, тендерийн жишиг маягт, гэрээний нөхцөл гэсэн бүлэгтэй.

Тендер шалгаруулалтын зааварчилгаа (цаашид “ТШЗ” гэх) бүлгийн зүйл, заалтыг нэмж, эсхүл өөрчилж үл болох бөгөөд захиалагч, оролцогч-сонирхогч этгээд нь тэдгээрийг баримтална. Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахдаа ТШЗ-нд үндэслэн, худалдан авах барааны онцлогийг харгалзан өгөгдлийн хүснэгт (ӨХ)-ийг боловсруулах ба шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн бэлтгэнэ.

Техникийн тодорхойлолт бүлэгт захиалагчийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой хэрэгцээ, шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгасан байна.

Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд үндэслэн жишиг маятуудын хаалт дотор налуугаар бичсэн тохирох мэдээллийг зааварт нийцүүлэн бүрэн, үнэн зөв бөглөж ирүүлнэ. Гэрээний нөхцөл бүлэг нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгууллагдах гэрээний зүйл, заалтууд тул талууд үүнийг судалсан байвал зохино.

Харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын анхаарах асуудлууд:

- ❖ Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээ /Бараа цахим каталогт бүртгэгдсэн байна./
- ❖ Тендер шалгаруулалтын зарлал нийтэлж, бүртгэлтэй аж ахуй эрхлэгчид урилга хүргүүлж, үнийн санал дуудна. Тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим систем [/www.tender.gov.mn/-д нийтэлнэ.](http://www.tender.gov.mn/)
- ❖ Үнийн саналыг дуудах хугацаа нь урилга хүргүүлсэн, зарлал нийтэлсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй өдрийн дараа байхаар тогтоосон байна.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдэд цахим системээс ялгах дугаар олгоно.
- ❖ Заасан хугацаанд сонирхогч этгээд тендерийг цахим системд ирүүлнэ.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагааг 2 хүртэл цагийн хугацаагаар зохион байгуулна. Уг хугацааны дотор саналыг бууруулан хэдэн ч удаа ирүүлж болно.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад өсөх дарааллаар **эхэнд эрэмбэлэгдсэн** үнийн санал бүхий оролцогчийг тодорхойлно.
- ❖ Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн **тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно.**

Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол **удаах эрэмбэлэгдсэн** тендерийг хянан үзнэ.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА.....	4
II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ.....	9
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА	11
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МЯГТ	19
V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ.....	23

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

		А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
1. Тендерийн цар хүрээ		1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "Хууль" гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгт (цаашид "ӨХ" гэх)-д заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид "бараа" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичгийг гаргаж байна. Зарлалын дугаар, тендер шалгаруулалтын нэр, дугаар, багцын мэдээлэл өгөгдлийн хүснэгтэд бичигдэнэ.
2. Санхүүжилтийн үүсвэр	эх	2.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
3. Худалдан ажиллагааны тогтоомж	авах хууль	<p>3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрднө.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.</p> <p>3.3. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцож эрхгүй.</p>
4. Оролцогч, сонирхогч этгээдэд тавигдах ерөнхий шаардлага		<p>4.1. Оролцогч хуулийн 7.1.1-7.1.9-д заасан нөхцөлийг хангасан байна.</p> <p>4.2. Түншлэлээр оролцох тохиолдолд түншлэлийн гишүүн бүр ерөнхий шаардлага хангасан байна.</p> <p>4.3. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.</p> <p>4.4. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.</p> <p>4.5. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.</p>
5. Туслан гүйцэтгэгч		<p>5.1. Хуулийн 6.4-т зааснаар тендерийн үнийн 20 хүртэл хувьтай тэнцэх гүйцэтгэлийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэх тохиолдолд туслан гүйцэтгэх үргийг гэрээнд заасан байна.</p> <p>5.2. Туслан гүйцэтгүүлэх хувь хэмжээ тендерийн үнийн 20 хувиас хэтэрсэн, эсхүл туслан гүйцэтгүүлэх тоо хэмжээг заагаагүй бол туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзүүхэд харгалзан үзэхгүй.</p> <p>5.3. Туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг туслан гүйцэтгэг цахим системээр баталгаажуулсан байна.</p>
6. Бараанд тавигдах ерөнхий шаардлага		<p>6.1. Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан бараа худалдан авахаас, эсхүл хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд оролцогч аль ч улсын гарал үүсэлтэй бараа санал болгож болно.</p> <p>6.2. Харьцуулалтын аргаар худалдан авах бараа Сангийн сайдын баталсан "Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид "цахим систем" гэх/-ээр зохион байгуулна.</p>
Б. АГУУЛГА		
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл		<p>8.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг дараах бүлэг болон түүний нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ.</p> <ul style="list-style-type: none"> I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгaa; II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт; III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага, бараа нийлүүлэлтийн хуваарь; IV Бүлэг. Тендерийн жишиг маягт; V Бүлэг. Гэрээний нөхцөл. <p>8.2. Тендер шалгаруулалтын зарлал, цахим системээр хүргүүлсэн урилга нь тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл болохгүй.</p>

	8.3.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
9.Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах	<p>9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.</p> <p>9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.</p> <p>9.3.Тодруулга авах хүсэлтийд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.</p> <p>9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн тооцно.</p> <p>9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 10-д заасныг мөрдөнө.</p>
10.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах	<p>10.1.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.</p> <p>10.2.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.</p> <p>10.3.Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.</p>
11.Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт	<p>11.1.Захиалагч сонирхогч этгээдийн тендер бэлтгэхтэй холбоотой асуултад хариулт өгөх уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>11.2.Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.</p> <p>11.3.Уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.</p>
В.ТЕНДЕР БЭЛТГЭХ	
12.Тендер шалгаруулалтын хэл	<p>12.1.Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.</p> <p>12.2.Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.</p> <p>12.3.Хэрэв ТШЗ-ны 12.2-т заасан тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.</p> <p>12.4.Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.</p>
13.Тендерийн бүрдэл	<p>13.1.Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:</p> <p>13.1.1.TШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;</p> <p>13.1.2.Тендерийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;</p> <p>13.1.3.TШЗ-ны 15-т заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;</p> <p>13.1.4.TШЗ-ны 16-т заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;</p> <p>13.1.5.бараа нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>13.1.6.санал болгож буй бараа ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцэснийг нотлох баримт бичиг;</p> <p>13.1.7.TШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;</p> <p>13.1.8.TШЗ-ны 22.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;</p> <p>13.2.Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.</p>
14.Тендерийн жишиг маягт	14.1.IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15.Хувилбарт санал	15.1. Хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг ирүүлэх шаардлагатай бол өгөгдлийн хүснэгтэд заана.
16.Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг	16.1.ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1. 16.2.Хэрэв өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 7.1-д заасан ерөнхий нөхцөлийг магадлахтай холбоотой баримт бичиг. 16.3.Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.
17.Чадавхын болон туршлагын шаардлага тавих үндэслэл	17.1.ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тавихад хуулийн 15 дугаар зүйлийг баримтална. 17.2.Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй. 17.3.Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.. 17.4.Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
18.Санхүүгийн чадавхын шаардлага	18.1.Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна. 18.2.Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. 18.3.Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалzan үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй. 18.4.Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
19.Техникийн чадавх болон туршлагын шаардлага	19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна. 19.2.Техникийн болон туршлагын чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. 19.3.Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.
20.Санал болгож буй бараанд тавигдах шаардлага	20.1.ТШЗ-ны 6.1-д заасан тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй. 20.2.Санал болгож буй барааны техникийн тодорхойлолтод нийцсэн болохыг нотлох баримтыг тендерт ирүүлнэ. 20.3.Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. 20.4.Хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй боловч шаардлага хангах бол түүнийг нотлох шаардлагатай.
21.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээ	21.1.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээтэй холбоотой өгөгдлийн хүснэгтэд заасан бол дараах баримт бичиг, мэдээллийг ирүүлнэ. Үүн: 21.1.1.санал болгож буй барааг тасралтгүй, горимын дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд ашиглахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт, авах боломжтой хаяг, тэдгээрийн үнийн мэдээлэл; 21.1.2.засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл. 21.1.3.годаадын этгээдийн хувьд нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлгөч гүйцэтгэх тухай баримт.
22.Тендерийн үнэ	22.1.Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна. 22.2.Тендерийн үнэ гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх эсэхийг өгөгдлийн хүснэгтэд заана. Өгөгдлийн хүснэгтэд тогтмол байхаар заасан тохиолдолд тохируулга хийх нөхцөлтэй тендер ирүүлсэн бол шаардлага хангагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь

	<p>гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.</p> <p>22.3.Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.</p> <p>22.4.Унийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендериин үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.</p> <p>22.5.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендериин үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.</p>
23.Тендериин валют	<p>23.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендериин үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлнэ.</p>
24.Тендер хүчинтэй байх хугацаа	<p>24.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээнээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.</p> <p>24.2.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 24.1-д заасан хугацааг сунгаж болно.</p> <p>24.3.Оролцогч хугацааг сунгасан бол хуулийн 28.9-д зааснаар бичгээр мэдэгдэнэ.</p>
Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ	
25.Тендер баталгаажуулах, илгээнэ	<p>25.1.Тендерииг хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулан илгээнэ.</p> <p>25.2.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендериийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.</p> <p>25.3.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> <p>25.4.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.3-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.</p>
26.Тендер хүлээн авах эцсийн хугацаа	<p>26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.</p>
Д.ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГАА	
27.Үнийн санал дуудах хугацаа	<p>27.1.Хуулийн 34.6-д зааснаар үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдийн тоо зарлалд заасан шаардлагатай тоонд хурсэн тохиолдолд уг ажиллагаа ТШЗ-ны 26.1-д товлосон хугацаанаас нэг цагийн дотор эхэнэ.</p> <p>27.2.Үнийн санал дуудах ажиллагаа хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу явагдана.</p> <p>27.3.ТШЗ-ны 27.2-т заасан ажиллагаа урилгад заасан хугацаанд үргэлжилж хаагдана.</p>
28.Тендер нээх	<p>28.1.ТШЗ-ны 27.3-т зааснаар хугацаа хаагдахад цахим систем оролцогч нарын санал болгосон эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлэх ба захиалагч зөвхөн эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендериийг нээнэ.</p>
Е.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ /ХЯНАН ҮЗЭХ	
29.Тендериийг шаардлагад нийцэх эсэхийг хянан үзэх	<p>29.1.Нээсэн тендериийг хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендериин бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендериийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн Сангийн сайдын баталсан зааврын дагуу хянан үзнэ.</p> <p>29.2.Тендерт ирүүлсэн аливаа баримт бичгийн үнэн зөв, хүчинтэй байдлыг шалгаж үзэх эрхтэй байна.</p> <p>29.3.Эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендериийг хянан үзнэ.</p>
30.Тендериийн талаар тодруулга авах	<p>30.1.Тендериийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална.</p>

Ё.МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
31.Мэдэгдэл хүргүүлэх	31.1.Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
32.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	32.1.Захиалагч ТШЗ-ны 8.1-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу эцэслэн нөхж, оролцогчид хүргүүлнэ. 32.2.Шалгарсан оролцогч ТШЗ-ны 32.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчийн тогтоосон хугацааны дотор хүргүүлнэ. 32.3.Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.
Ж.БУСАД	
33.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлах	33.1.Захиалагч ТШЗ-ны 29.3-т зааснаар хянан үзээд бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтыг дахин зарлах эсэх мэдээллийг хуулийн 28.1.3-т заасан шийдвэрт заана. 33.2.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлахад хуулийн 34.11-д заасныг баримтална.
34.Тендер шалгаруулалтад гомдол гаргах	34.1.Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХУСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагчийн нэр: [9-р цэцэрлэг]
ТШЗ 1.1	Зарплын дугаар: [ОРА9Ц/202401009] Тендер шалгаруулалтын нэр: [Хоол, хүнс] Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр: [Багц №1: Мах, махан бүтээгдэхүүн Багц №2: Талх, нарийн боов Багц №3: Сүү, сүүн бүтээгдэхүүн Багц №4: Төмс, хүнсний ногоо Багц №5: Бусад хүнсний бүтээгдэхүүн]
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр: [Улсын төсвийн урсгал төсөө] /Нийт санхүүжилтээс 1,2,3-р сарын төсвийг хассан дүн болно/ Нийт төсөвт өртөг: [57300.000] [Багц № 1: Мах, махан бүтээгдэхүүн 21750.000 Багц № 2: Талх, нарийн боов 4227.000 Багц №3: Сүү, сүүн бүтээгдэхүүн 10930.000 Багц №4: Төмс, хүнсний ногоо 8280.000 Багц №5: Бусад хүнсний бүтээгдэхүүн 12113.000]
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.2	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хариуцсан ажилтан: [9-р цэцэрлэгийн ня-бо Л.Түмэн-Өлзий] Хаяг: [Уурхайчин баатар, өөрийн байр] Утасны дугаар: [99365179] Цахим шуудан: [tumenujzii06@gmail.com]
ТШЗ 11.1	Тендер ирүүлэх өмнө уулзалт зохион байгуулах эсэх: [“ҮГҮЙ”]
В.ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: [“ЗӨВШӨӨРӨХГҮЙ”]
ТШЗ 16.2	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг: - Шүүхийн тодорхойлолт - Татварын тодорхойлолт - Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ, гэрээ дүгнэсэн акт
ТШЗ 18.1	Санхүүгийн чадавхын шаардлага: - Сүүлийн 1 жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх - Тухайн тендер нээсэн өдрийн байдлаар өр, төлбөргүй байна.
ТШЗ 18.2	Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг: - 2023 оны хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан
ТШЗ 19.1	Техникийн чадавх болон туршлага: [“Шаардана”] Ижил төстэй гэрээний туршлага: [“Шаардана”] Ижил төстэй гэрээний мэдээлэлийг IV бүлгийн Маягт 3-аар ирүүлэх Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын шаардлага: []
ТШЗ 19.2	Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: Гэрээний үүргийг гүйцэтгэхтэй холбоотой машин механизмын, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн байрны шаардлага: - Тендерт оролцогч нь үйл ажиллагаа явуулдаг ажлын байр, хадгалах зориулалтын агуулах, ачиж тээвэрлэх эрүүл ахуйн шаардлага хангасан машинтай байх /фото зураг, гэрчилгээ, түрээсийн бол түрээсийн гэрээ зэрэг нотлох баримт бичгийг ирүүлэх/ - Нийлүүлэх барааны зургийг өнгөтөөр, харагдах байдал бүрэн тодоор ирүүлэх - Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ. /хуулийн 27.13 дахь заалтын дагуу НӨАТ тооцсон үнээр ирүүлэх/ Жич: Дээрхи мэдээлэлүүдийг дутуу ирүүлсэн болон ирүүлээгүй тохиолдолд мөн худал мэдээлэл ирүүлсэн нөхцөлд тендерээс татгалзах үндэслэл болно.

ТШЗ 19.3	Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ шаардлагатай эсэх: [Тохирлын гэрчилгээтэй байх Багц 2, 3]
ТШЗ 21.1	Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээний талаарх мэдээлэл ирүүлэх эсэх: ["ҮГҮЙ"] Санал болгож буй барааг тасралтгүй, горимын дагуу ашиглах хугацаа: [0] Нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээтэй холбоотой бусад шаардлага: [0]
ТШЗ 22.2	Оролцогчийн санал болгосон тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: ["ТОХИРУУЛАХГҮЙ"]
ТШЗ 22.3	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: ["ТИЙМ"] Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь DDP-Үнээр санал болгоно. Бараа хүргэх газар: Орхон аймгийн Уурхайчин баг 3-р хороолол 9 дүгээр цэцэрлэг Бүх зардал, эрсдэлийг худалдагч буюу тендерт оролцогч хариуцана.
Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ	
ТШЗ 25.4	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас скайнердаж ирүүлэх 2. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх 3. Захирлын цахим иргэний үнэмлэх эх хувиас скайнердаж ирүүлэх 4. Шүүхийн тодорхойлолт: Сүүлийн 1 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ зөрчсөн эсэх талаарх харьяа шүүхийн тодорхойлолт эх хувиас скайнардаж ирүүлэх 5. Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт ирүүлэх. Тодорхойлолт нь тендер зарлагдсан хугацаанаас хойш авсан байх шаардлагатай бөгөөд тухайн тендер нээсэн өдрийн байдлаар өр, төлбөргүй байна. 6. Тендерт оролцогч нь уг ажлын техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах этгээдтэй нэгдмэл сонирхолтой эсэх талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх 7. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх 8. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид гэрээний хугацаанд тогтмол үнээр нийлүүлэх тухай баталгааг албан бичгээр гаргаж тендерт ирүүлэх <p>Жич: Дээрхи мэдээлэлүүдийг дутуу ирүүлсэн болон ирүүлээгүй тохиолдолд мөн худал мэдээлэл ирүүлсэн нөхцөлд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТШЗ 26.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Огноо: [2024.04.04] Цаг: [10 цаг 40 минут]

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардлагадах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглаадаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтийг нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайллан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

ЭРХЛЭГЧ

БАТЛАВ

Х.САНСАРТУЯА

Техникийн тодорхойлолт

Санал болгох барав нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцэн байна. Хуулийн 26.8-д заснаар эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодоттол хэрэглэсэн техникийн тодорхойлолтод өөр барав санал болгосон оролцогч техникийн тодорхойлолтод засансантай дүйцэх болохыг ТШЗ 20.2-т зассан баримт бичгээр нотолсон бол техникийн тодорхойлолтыг хангасан гэж үзүү.

Барааны нэр: Мах, махан бүтээгдэхүүн

№	Захиалаачийн техникийн тодорхойлолт (Тухайн баравын үзүүлэлт тус бүрийн дөржжасааж бичих ба хэрээ чанарын баталгаамт хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (Зөвхөн санал болгож буй баравын техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийн нотлох баримт бичиг болон танилцууллыг хөвсөргана)
1	Эрүүл ахуй, ариун цэврийн стандартад нийцэн, гарал ўсслийн гэрчилгээ бүхий, 1 дүгээр зэргийн, өнгө, үнэр, биет байдал, гадаргуу, хэлбэр алдагдаагүй, монгол аргаар төхөөрөн мах байна. Ухрийн мах MNS2456:2009, хонини мах MNS1111:2007		

Барааны нэр: Талх, нарийн боов

№	Захиалаачийн техникийн тодорхойлолт (Тухайн баравын үзүүлэлт тус бүрийн дөржжасааж бичих ба хэрээ чанарын баталгаамт хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (Зөвхөн санал болгож буй баравын техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийн нотлох баримт бичиг болон танилцууллыг хөвсөргана)
1	Бүтээгдэхүүний чанар, хэлбэр, өнгө гадаргуу, амт үнэр зэрэг стандартын шаардлага хангасан үйлдвэрт баталгаажсан жор технологийн зааврыг баримтлан үйлдвэрлэсэн, хүүхэд идахэд зориулсан хэмжээ бүтэцтэй, зориулалтын сав баглаваа боодлой бүтээгдэхүүн байх. Атар, Өргөө зэрэг үйлдвэрийн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц Талх MNS4661:1998, печенин боов MNS0659:74, Жигнэмэл боов MNS2488:1998, хеелгечтэй боов MNS4578:1998		

Барааны нэр: Сүү, сүүн бүтээгдэхүүн

№	Захиалаачийн техникийн тодорхойлолт (Тухайн баравын үзүүлэлт тус бүрийн дөржжасааж бичих ба хэрээ чанарын баталгаамт хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (Зөвхөн санал болгож буй баравын техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийн нотлох баримт бичиг болон танилцууллыг хөвсөргана)
1	Эрүүл ахуй, ариун цэврийн стандартад нийцэн, гарал ўсслийн гэрчилгээ бүхий сүү болон тараг, аарц, ааруул зээгий нь үйлдвэрийн аргаар боловсруулсан өнгө, үнэр, биет байдал, амт чанар хэвийн. Тохирлын гэрчилгээтэй байна. Уламжлалт аргаар хийгдсэн, чихэргүй байх. Сүү MNS4228:2011, тараг MNS0659:74, аарц MNS4230:2005, цэцгий MNS 4520:1998, ааруул зээгий MNS4230:2005		

Барааны нэр: Төмс, хүнсний ногоо

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	Орон нутагт тариалсан, сайн чанарын ногоотой дүйцэхүйц, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардлага хангасан, өнгө, үнэртгүй, биет байдал, гадаргуу цэвэр шороогүй, хэлбэр алдагдаагүй, зориулалтын зооринд зөв хадгалсан, ямар нэг химийн бодисоор бордогдоогүй, бохирдоогүй байх. Төмс MNS 0258:2006, лууван MNS 0271:1982, байцаа MNS 0255:2007, манжин MNS 0258:2006, сонгино MNS 0260:1982, чинжүү MNS 0279:1982, сармис орос MNS 0267:1973, огурцы MNS ISO7560:2003, хулуу MNS 0255:2007, помидор MNS 0264:2009, бууцай MNS 0255:2007, аньс MNS 1990:2014, алим – орос улсад үйлдвэрлэгдсэн сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандартад нийцсэн байна.		

Барааны нэр: Бусад хүнсний бүтээгдэхүүн

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)
1	1 дүгээр зэргийн Улаанбаатар, Алтан тария зэрэг гурил, лапша гоймон, печенъетэй дүйцэхүйц, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардлага хангасан, өнгө хэвийн, үнэртгүй, илчлэг чанар сайн, хадгалалт тээвэрлэлтийн горим алдагдаагүй ямар нэг химийн бодисоор бохирдоогүй байх. Гурил MNS 0244:2009, бүхэл үрийн гурил MNS ISO 7301:2000, лапша гоймон MNS 6142:1985, печенье MNS 0185:1985, хуурай цай MNS ISO 7301:2000, цагаан будаа MNS ISO 7301:2000, гурвалжин будаа MNS ISO 7301:2000, хөц будаа MNS ISO 7301:2000, шар будаа MNS0533:1962, Монгол хөрсөнд ургасан байгалин зэрлэг жимс байх бөгөөд иш навч шилбэнээс салгасан, исээгүй, няцраагүй, амт үнэр өөрчлөлтгүй, сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн, технологийн шаардлага хангасан гадаад байдал амт ба үнэр боловсролт зэргийг баримталсан байна. Аньстай дүйцэхүйц витаминалаг чанартай. Аньс, бусад жимс- MNS 1990:2014		
	Импортын бүтээгдэхүүнүүд: Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн, Слава болон Орос улсад үйлдвэрлэгдсэн		

	<p>бүтээгдэхүүндтэй дүйцэхүйц, өнгө хэвийн, үнэргүй, ямар нэг химиин бодис, хортон шавьжаар бохирдоогүй байх.</p> <p>Цагаан будаа MNS ISO7301:2000, шар будаа MNS 0532:1998, хөц будаа MNS 4515:1997, каша MNS 0243:2003, вандуй MNS 0264:2009, овъёос MNSCAC 192:2015, исгэгч MNSCAC 192:2015, ургамлын тос MNS 6421:2013, элсэн чихэр MNS 9920:1986, давс MNS 5131:2002, гоймон MNS 6142:1985, үзэм MNS ISO7560-2003,</p> <p>Алим- Орос улсад үйлдвэрлэгдсэн Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн, MNS1990:2014</p>		
--	---	--	--

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хуртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
				Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
2	3	4	5	6	7
1. Мах, махан бүтээгдэхүүн					
Үхрийн мах	900	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Хонини мах	1200	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
2. Талх, нарийн боов					
Цагаан талх /том/	150	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Загасан талх	50	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Бүхэл үрийн талх	200	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Жигнэмэл боов хөөлгөгчгүй /тослогт-60, еэвэн-60, бүхэл үрийн еэвэн-100/	220	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Хөөмөл боов, боорцог /цайны-200, мушгиа-60/	260	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
3. Сүү, сүүн бүтээгдэхүүн					

Сүү	2000	л	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Тараг	600	л	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Аарц	30	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Цөцгийн тос	20	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Ааруул	10	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	

4. Төмс, хүнсний ногоо

Төмс	1000	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Байцаа	800	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Лууван	600	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Хүрэн манжин	200	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Чинжүү	40	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Брокли	50	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Огурцы	50	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Помидор	50	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Сармис	20	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	

Сонгино	250	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	
Бууцай, юуцай	50	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал	

5.Бусад хүнсний бүтээгдэхүүн

Гурил 1-р	500	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Гурил бүхэл үр	40	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Цагаан будаа	300	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Гурвалжин будаа /Oros/	330	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Шар будаа /Oros/	200	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Хөц будаа /Oros/	100	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Хүүхдийн будаа /Oros/	120	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Эрдэнэшишийн каш 600гр	90	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Варень 850 гр /Oros/	50	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Овъёос 400гр /Oros/	130	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Вандуй 900 гр /Oros/	100	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Исгэгч 12гр	50	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал

Ургамлын тос 1кг /Янта/	70	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Элсэн чихэр /Орос/	200	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Далайн байцаа 100гр /шөл/	10	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Далайн байцаа 25гр /кимбаб/	60	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Давс /Орос/	60	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Цай /том/	5	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Үзэм	60	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Гоймон /лапша/	50	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Шпагетти гоймон 400гр /Орос/	100	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Хөндий гоймон макбур /Орос/	60	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Масло /Oros/	50	кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Печенье /Аз жаргал/	54	ш	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Чацаргана	20	л	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Алим	30	Кг	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал
Анъс	10	л	9-р цэцэрлэг	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 2024.12.31-нийг дуустал

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Захиалагч энэ бүлэгт оролцогчийн бөглөх шаардлагатай бүх маягтыг тусгана.

Маягтын жагсаалт:

Маягт 1: Тендер илгээх маягт	20
Маягт 2: Барааны үнийн задаргаа	20
Маягт 3: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл.....	21
Маягт 4: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл	22
Маягт 5: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл	22
Маягт 6: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт.....	22

Маягт 1: Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтын үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон үнээр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 3.1. Захиалгачийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 4.1. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна¹.
5. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
6. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
7. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

Баталгаажуулсан: Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг мэдээлэл:

Маягт 2 Барааны үнийн задаргаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс ²	Тоо хэмжээ	Хэм жих нэгж , тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүл эхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ³
1										Тийм/Үгүй
2										
...										
Тендерийн нийт үнэ										

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:

Маягт 3: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

² ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

³ Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 4: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 5: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 6: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний өрөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь захиалагч, гүйцэтгэгч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно.

Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох бараа худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол ГТН-ийн холбогдох заалтад тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан өөрчлөлт оруулан ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсарах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөхгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, too хэмжээ зэрэгт нийцүүлэн тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР	
Тодорхойлолт	<p>1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:</p> <p>1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;</p> <p>1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;</p> <p>1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;</p> <p>1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;</p> <p>1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;</p> <p>1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;</p> <p>1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.</p> <p>1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;</p> <p>1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;</p> <p>1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;</p> <p>1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;</p> <p>1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хэл хориотой өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.</p>
Гэрээний тайлбар	<p>1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:</p> <p>1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.</p> <p>1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.</p> <p>1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлахад бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.</p> <p>1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсэн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.</p> <p>1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсэн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.</p>

ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

Бараа нийлүүлэх	<p>2.1.Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй</p> <p>2.2.Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна</p> <p>2.3.ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.</p> <p>2.4.Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.</p>
Бараа нийлүүлэх газар	2.5.Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	<p>2.6.Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.</p> <p>2.7.Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <p>2.7.1.Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</p> <p>2.7.2.Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.</p> <p>2.8.Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>2.9.ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.</p>
Барааг хүлээлгэн өгөх	<p>2.10.Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.</p> <p>2.11.Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.</p>
Барааны гарал үүслийн улс	<p>2.12.Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.</p> <p>2.13.Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.</p>
Баглаа боодол	<p>2.14.Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хийнэ.</p> <p>2.15.Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа бооддолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.</p> <p>2.16.Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрднө.</p>
Худалдааны нөхцөл	<p>2.17.Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.</p> <p>2.18.ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарыт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.</p>

ГУРАВ. ЗАХИАЛАГЧ

Барааг хүлээн авах	3.1.Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
Шалгалт, туршилт	3.2.Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
	3.3.Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой

	<p>тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.</p> <p>3.4.ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.</p> <p>3.5.Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.</p> <p>3.6.Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.</p>
Гэрээний үнэ	<p>3.7.Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.8.Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.</p>
Төлбөр төлөх	<p>3.9.Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнэ.</p>
	<p>3.10.Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>3.11.Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>3.12.Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.</p> <p>3.13.ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p> <p>3.14.Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>3.15.Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс сутгана.</p>
ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА	
Захиалагчийн хүлээх эрсдэл	<p>4.1.Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>4.1.1.Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;</p> <p>4.1.2.Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.</p>
Даатгал	<p>4.2.Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийт Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.</p>
Доголдол	<p>4.3.Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.</p>
	<p>4.4.Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.</p>
	<p>4.5.Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.</p>
	<p>4.6.Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.</p>
	<p>4.7.Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.</p>
	<p>4.8.Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнэ.</p>
	<p>4.9.Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас сутгаж болох бөгөөд Чанарын баталгааг хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнэ.</p>
Чанарын баталгаа	<p>4.10.Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.</p> <p>4.11.ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.</p> <p>4.12.Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.</p>

	<p>4.13.ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>4.14.Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнэ.</p> <p>4.15.ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16.ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p>
Алданги	<p>4.17.Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлэгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнэ.</p> <p>4.18.Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнэ.</p>
Оюуны өмчийн эрх зөрчих	<p>4.19.Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p>
Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал	<p>4.20.Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>4.21.Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p>
	<p>4.22.Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>4.23.Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.</p>
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа	<p>4.24.Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>4.25.Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p>
ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ	
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл	<p>5.1.Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:</p> <p>5.1.1.Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүй улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;</p> <p>5.1.2.Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;</p> <p>5.1.3.Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.</p> <p>5.1.4.Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.</p> <p>5.2.Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.</p> <p>5.3.Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.</p> <p>5.4.Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг</p>

	хэрэгжүүлэхгүй.
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл	5.5.Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.
ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ	
Төлөөлөгч	<p>6.1.Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>6.2.Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.</p> <p>6.3.Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.4.Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориллоно.</p>
Туслан гүйцэтгэгч	<p>6.5.Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>6.6.Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.</p>
Нууцлал	<p>6.7.Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсэн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>6.8.Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.</p>
Мэдэгдэл	<p>6.9.Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>6.10.Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжктэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.11.Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>6.12.Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <ul style="list-style-type: none"> 6.12.1.баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн; 6.12.2.биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн. <p>6.13.Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>6.14.ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p>
Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах	<p>6.15.Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:</p> <ul style="list-style-type: none"> 6.15.1.ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан; 6.15.2.үнийн тохирнуулга хийсэн.
	6.16.Гэрээний нэмэлт, өөрчлөлтэд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
	6.17.ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
Маргаан шийдвэрлэх	6.18.Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
	6.19.Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.5.	Бараа нийлүүлэх газар: [Орхон аймаг Баян-Өндөр сум Уурхайчин баг 9 дүгээр цэцэрлэг]
ГЕН 2.6.	Бараа нийлүүлэх хугацаа: [Гэрээ байгуулсан өдрөөс нийлүүлэлтийн хуваарийн дагуу 2024 оны 12 дугаар сарын 31 хүртэл]
ГЕН 2.10.	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: [Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх]. Бараанд холбогдох баримт бичиг: [Барааг хүлээлгэн өгсөн зарлагын баримт, гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний бичигтэй байх]
ГЕН 2.14.	Баглаа, боодол: [Нийлүүлэгч барааг хүлээлгэн өгөх эцсийн цэг хүртэл тээвэрэх явцад гэмтэж зөвдэрэхээс сэргийлэх зорилгоор сав баглаа, боодол болон тээвэрлэлт, ачиж буулгахад анхаарна. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тунадас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бурд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна]
ГЕН 2.16	Баглаа боодол түүний дотор гадна талд тэмдэглэгээ хийх: [Савалгаан дээр үйлдвэрлэсэн огноо үнэн зөв бичигдсэн байх]
ГЕН 2.17.	Худалдааны нөхцөл: [Олон улсын худалдааны Incoterms /Инкотермс -ийн хувилбар: "Incoterms 2020" Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь DDP-Үнээр санал болгоно]
ГЕН 3.8.	Үнийн тохируулга хийх аргачлал: "Ажиллах хүч болон материалын үнийн өөрчлөлтийг тусгах зорилгоор гэрээний хэрэгжилтийн явцад нийлүүлэгчид төлөх үнийг дараах томъёог ашиглан тохируулна: $DP = P_0 (a + b \underline{L}_1 + c \underline{M}_1) - P_0$ $L_0 \quad M_0$ <p>Үүнд:</p> $DP - \text{нийлүүлэгчид төлөх нэмэгдэл үнэ}$ $P_0\text{-гэрээний үндсэн үнэ};$ <p>a -гэрээний үнэд шингэсэн ашиг, захиргааны зардлын тогтмол дүн. Ихэнх тохиолдолд 5-15 хувийн хооронд хэлбэлздэг;</p> <p>b -гэрээний үнэд ажиллах хүчний эзлэх хувь;</p> <p>c -гэрээний үнэд материалын эзлэх хувь;</p> <p>L_0-гарал үүслийн улсын холбогдох салбарын ажиллах хүчний өдрийн индекс;</p> <p>L_0, L_1 -гарал үүслийн улсад мөрдөгдөж буй холбогдох салбарын ажиллах хүчний суурь өдрийн болон үнэ тохируулах өдрийн индекс;</p> <p>$M_1 M_0$ -гарал үүслийн улсад мөрдөгдөж буй үндсэн барааны суурь өдрийн болон үнэ тохируулах өдрийн индекс.</p> <p>[захиалагч a, b, c итгэлцүүрүүдийг тендерийн баримт бичигт заана. Энэ гурван итгэлцүүрийн нийлбэр дүн аль ч тохиолдолд нэг (1) байна.]</p> <p>Тендерт оролцогч индексийн эх үүсвэр болон суурь өдрийн индексийг өөрийн тендерт зааж өгнө.</p>

	<p><i>Суурь өдөр нь тендер зарласан өдөр байна.</i></p> <p><i>Үнэ тохируулах өдөр нь барааг тээвэрлэхээс [тоо бичих]⁴ долоо хоногийн өмнөх өдөр байна (үүнийг үйлдвэрлэх явцын дунд үе гэж ойлгоно).</i></p>
ГЕН 3.9.	Төлбөр төлөх хугацаа: [Дараа сарын 5-ны дотор барааг хүлээн авсан баримт бичгийг үндэслэн төлбөрийг төгрөгөөр бэлэн бусаар төлнө]
ГЕН 4.2.	Даатгал: []
ГЕН 4.10.	Баталгаат хугацаа: [Заагаагүй]
ГЕН 4.11	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: [Чанарын баталгаа шаардахгүй] Чанарын баталгааны дүн: [0]
ГЕН 4.17.	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: [“Үгүй”] Алдангийн хувь: [0]
ГЕН 4.18.	Захиалагчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: [“Үгүй”] Алдангийн хувь: [0]

⁴Захиалагч шаардлагатай долоо хоногийн тоог заана.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэрийг бичих] (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
 2. Гэрээний үнийг Нийлүүлэгч [Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
 3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Техникийн тодорхойлолт;
 - 3.6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
 4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө.
Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: [2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр]
Тендер шалгаруулалтын төрөл: Бараа
Тендер шалгаруулалтын нэр: [Хүүхдийн хоол, хүнс]
Тендер шалгаруулалтын дугаар: [ОРА9Ц/202401009]
Нийт төсөвт өртөг: [57300.000]
Тендер шалгаруулалтын арга: Харьцуулалт

- [Орхон аймгийн 9 дүгээр цэцэрлэг] нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: [“Тийм”]

Багц № 1: Мах, махан бүтээгдэхүүн,
Багц № 2: Талх, нарийн боов,
Багц № 3: Сүү, сүүн бүтээгдэхүүн,
Багц № 4: Төмс, хүнсний ногoo,
Багц № 5: Бусад хүнсний бүтээгдэхүүн

Дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах бараа бол тодорхой бичих:

Дотоодын багц № 1: Мах, махан бүтээгдэхүүн,
Дотоодын багц № 2: Талх, нарийн боов,
Дотоодын багц № 3: Сүү, сүүн бүтээгдэхүүн,
Дотоодын багц № 4: Төмс, хүнсний ногoo,
Дотоодын багц № 5: Бусад хүнсний бүтээгдэхүүн

- Үнийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: []
- Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам: []
- Үнийн санал дуудах ажиллагааг []-т эхлүүлж, [] хугацаанд зохион байгуулна.
- Тендерийг [2024 оны 4-р сарын 04-ний өдрийн 10 цаг 40 минут]-аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг [2024 оны 4-р сарын 04-ний өдрийн [11 цаг 30 минут]-т нээнэ.
- Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: [“Зөвшөөрөхгүй”]
- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: [“Эрхгүй”]
- Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
- Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж 50000 /Тавин мянган/ төгрөг төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

[Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уурхайчин баг, 9-р цэцэрлэг,
2 давхар нягтлан бодогчийн өрөө, утас: 99365179
email: tumentulzii06@gmail.com]